

Алдарт дуучин Жигзавын Дорждагвын бүтээлийн сан хөмрөгийн судалгаа

Цэндийн Наранчимэг 

Соёл урлагийн их сургуулийн Соёлын сургууль,
Улаанбаатар, Монгол Улс
✉ tstsn91@gmail.com

Хураангуй: Монгол Улсын соёлын биет бус өв болсон уртын дууны их мастер, XX зууны манлай уртын дуучин, Алдарт гавьяат дуучин Жигзавын Дорждагвын бүтээл туурвилыг залуу хойч үед уламжлан сэргээн авч үлдэх, хориглогдсон дуу, аялгууг хадгалан хамгаалах зорилгоор “Их дуучны өв” болон “Сан хөмрөгийн хадгалалт хамгаалалт” нэртэй судалгааны чиглэл бүхий нэгэн талбарыг буй болгосон нь энэхүү өгүүллийн үндэслэл болно. Иймд түүний уртын дууны өв соёл, бүтээл туурвил, уртын дууны хөгжилд оруулсан хувь нэмэр, залуу үедээ уламжлан үлдээх, сурталчлах, арга барилыг түгээн дэлгэрүүлж, судалгааны эргэлтэд оруулахыг зорьж байна.

Алдарт гавьяат Дуучин Жигзавын Дорждагвын бүтээлийн сан хөмрөгийн судалгаа нь монголын ард түмний соёлын өвийг хадгалж, түүний урлагийн замнал, уран бүтээлийн онцлогийг судлах, залуу үед өвлүүлэх чухал ач холбогдолтой. Энэхүү судалгаа нь монголын дуу хөгжмийн түүхэнд үнэтэй хувь нэмэр оруулж, түүний дуу хоолойн өвөрмөц чанар, чансаа, арга барил, дэг сургууль, зохиосон бүтээлийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмэр болно.

Түлхүүр үгс: *тэмдэглэл, салбар судалгаа, хөмрөгийн баримт, эх материал, цуглуулга*

Fund research of works of famous singer Dorjdagva Jigzav

Naranchimeg Tsend 

School of Culture, Mongolian National University of Arts and Culture,
Ulaanbaatar, Mongolia
✉ tstsn91@gmail.com

Abstract: In order to preserve the work of Dorzhdagva Jigzav, the great master of urt songs, the leading urt singer of the 20th century, and the famous honored singer, who is the intangible heritage of Mongolia's culture, “The Legacy of the Great Singer” and “Preservation of Treasures” were created in order to preserve and preserve the forbidden songs and melodies The basis of this article is the creation of a research field named

“protection”. Therefore, we intend to pass on to the younger generation the heritage and culture of long songs, his creations, contributions to the development of long songs, spread the methods, and put them into the circulation of research.

The research of famous singer Dorzhdagva Jigzav’s collection of works is important to preserve the cultural heritage of the Mongolian people, to study his artistic career and the features of his art, and to pass it on to the youth. This study will make a valuable contribution to the history of Mongolian music and will contribute to the dissemination of the uniqueness of his voice, his ranking, methods, styles, and compositions.

Keywords: *notes, field research, documentary evidence, source material, collection*

Оршил

Энэхүү судалгааны ажлын хүрээнд зохиосон бүтээлүүдийг шүүн, сан хөмрөг үүсгэж, судалгааны ном, гарын авлага, сэтгүүл, радио телевиз, төрөлжсөн архивуудад хадгалагдаж байгаа сан хөмрөгийн мэдээллүүдийг цуглуулан ашигласан.

Түүний бүтээлийн сан хөмрөг, үлдээсэн өвөөс харахад уртын дууны хөгжилд үнэ цэнтэй хувь нэмэр оруулж, монголын уртын дууны сургалт судалгааны суурийг тавилцсан соён гэгээрүүлэгч, судлаач, сурган хүмүүжүүлэгч, багш болох нь харагдаж байна.

Ж.Дорждагвын зохиосон уран бүтээлийн сан хөмрөгт 55 орчим бүтээл, “монголчуудын олон зууныг дамжуулан тээж ирсэн урлагийн хосгүй төрөл уртын дууны сонгодог дэг сургуулийг бүрэн төгс эзэмшсэн алдарт дуучны амьд яриа, уламжлалт хөгжмөө гаргуун мэддэг судлаач сэтгэгчийн онож асууж, олж лавлаж байгаа арга ухаан хоёр түүхэн болоод эрдэм судлалын өргөн хүрээг хамарч байгаа далай” (Жанцанноров 2005, 11)-г судалж үзэхэд олон хуудас болох эх сурвалжууд байна.

Судалгааны арга зүй

Шинжлэх ухааны суурь арга зүй намтар судлал, системийн онолын “хүн төвт тогтолцооны хандлага”-ыг ашиглаж судалсан.

Судалгааны үр дүн

Нэг: Ж.Дорждагва нь соён гэгээрүүлэгч, сурган хүмүүжүүлэгч багш, арга зүйч, шилдэг зөвлөгч. Алдарт гавьяат Жигзавын Дорждагва нь XIX-XX зууны уртын дууг нуруун дээрээ үүрч гарсан гавьяатай. Тэрээр XIX-XX зууны бүхий л уртын дуучдад уртын дууг зааж сургаж өвлүүлсэн. 1974, 1976 онд хичээллүүлсэн уртын дууны курсийн дуучдыг бэлтгэн төгсгөсөн нь хожмоо монголын нэр хүндтэй дуучид төрөхөд нөлөөлөхөөс гадна 1968 онд уртын дууны уралдааныг санаачлан зохион байгуулжээ. “Дуучин Цогтын Чимидцэрэн, Магсархурцын Дугаржав, Балингийн Лувсангомпил, Гэлэнхүүгийн Поврон, Самын Гомбо нарын багш нараасаа уртын дууны арвин эрдмийг өвлөн авсан. Нутгийн нэрд гарсан дууч Цогтын Чимэдцэрэнгийн дуулахыг сонирхон, хэдэн хоногоор дагаж дуу заалгасан нь дуучин болох гарааг нь тавьсан байна. Чимэдцэрэн Дорждагвыг сайн дууч болно гэж дур хүслийг нь хөгжөөн дэмждэг байжээ” (Дашдорж, Цоодол 1971, 118). “Ж.Дорждагвыг бага байхад нь Хөндлөн Базар гэж нутгийн дэгжин эр зудын гүзээ гээд л балчир хүүг тэвэрч авч эрхлүүлдэг байж. Тэрээр жүжүүваа гэж орилохгүй юу.

Түүнийг дуурайж хашгирахад л миний хүү уртын дууч болох нь гэж судас баригдсан байгаа юм. Хийдэд шашны ном заалгахын хажуугаар нутгийн сайн дуучин, их гоёмсог, сайхан юм эдэлдэг, сайн балетмейстер буюу цам дэглэдэг Цогтхүндийн Чанид Чимэдцэрэнд “За Чимэдцэрэн минь би хүүгээ нэг шавь оруулж өгөх гэсйямаа. Чи миний хүүг нэг дууч болгож үзээрэй. Миний хүү дуулж л явах түүхтэй хүн юм шүү дээ” (Жанцанноров 2023) гэж хэлснээр алдарт багшаар Боржгин, Баянбараат аялгуугаар уртын дуу дуулах эрдмийг анх заалгасан байна.

1932 онд Бөмбөгөр ногоон театрт дуучнаар орсон цагаас эхлэн Магсархурцын Дугаржав багшаараа уртын дууны эрдмийг гүнзгийрүүлэн заалгажээ. “Аливаа дууны аялгууг чихний сонор сайхан мэдрэлээр татаж, тархи ухааны уран сайхан мэдрэлд тогтоох, хоолойн донж, гоо сайхан мэдрэлээр үгний хуваарь, хэмжээ хийцийг чимэглэн гаргасны хойно сая энэ гурван уран нийлээд яруу найруулга бүхий уран сайхны аялгуу бүрдэж чадна” (Дугаржав 1936, 16). Дугаржав багш энэ зарчмыг баримталдаг. Тэрээр өдрөөр морьтой явж байхдаа ардын богино дуугаа аялаад, урт дуугаа найран дээр зааж сургадаг байсан. Өөрөө эхлээд дахин дахин дуулаад сонсоно. Дараа нь шавиараа дуулуулаад дутуу байгаа, энд тэнд хэрэгтэй нугалаа хугалаа, шуранхайлах зэргийг нэгд нэгэнгүй хэлж заадаг байсан. Дугаржав багшдаа нэг өдөр очиж сурсан шинэ дуугаа дуулж зөвлөгөө авах гэсэн нь “Чи хоолой сайтай залуу юм. Гэвч чамд үзэж сонсож дууриал авах нэг хүн бий” гэж очсон нь Лувсангомпил дуучин байсан. Б.Лувсангомпил багш нь Сүжигт бэйс Дэмчигваанжил ноёны хатан байсан ба Богд хааны болон төрийн найруудад очиж дуулдаг, Боржгин, Баянбараат аялгуугаар дуулдаг, маш олон дуу мэддэг дуучин байжээ. Багшаараа хар дэл аялгуугаар уртын дууг заалгасан байна. Лувсангомпилын дуулах нэг онцлог бол гүтгэлэгтэй дуулдаг ба илүү сайхан болгодог арга. Ардын дууг чихэнд чимэгтэй, налмийлгаж (маш зөөлөн), үгийг их цэвэрхэн хэлдэг, намбалаг дуулдаг (Жанцанноров 2023). “Багш нэг хичээлийн явцад нэг дууг 20-30 удаа аялж өгдөг ба долоо хоногт 2-3 удаа хичээлээ заадаг. Дорждагва түүнийг маш сайн сонсоод гэртээ очиж сургуулилт хийгээд багшдаа шалгуулдаг байсан” (Оюунцэцэг 2010, 83).

Ж.Дорждагва нь багшийнхаа захиснаар ерөнхий сайд А.Амар гуайн тусламжтайгаар Цэцэн хан аймгийн хошууны /одоогийн Хэнтий аймгийн/ Самын Гомбо багшаараа гурван жил шахам уртын дуу заалгаж, зүүн аймгийн ба Боржгин аялгуугаар олон уртын дуу дуулж сурсан байна. “Хурх Биндэр аялгуугаар дуулдаг ба гарын уртай, маш сайхан уран хүн байсан. Гомбо багшийн гол онцлог бол сэтгэлгээтэй дуулдаг ба үгийг бол ясыг нь гартал тод сайхан хэлнэ. Дуугаа дуулахдаа үнэн голоосоо итгэж, тэрнийг бодож, тэр хэлж байгаа шүлгийнхээ дүрийг гаргаж дуулдаг дотуур сэтгэлгээ их сайтай дууч. Түүнийг багш Лувсанбалдангаасаа сурсан. Нүд ам гэдэг чинь шилбүүрдээд л, босоод гүймээр ч болох шиг тийм сэтгэлгээтэй дуулдаг. Уртын дууны дорвитой тохитой хэлбэртэй тийм дууч. Хурх Биндэрийн аялгуу бол Хар дэл аялгуунаасаа цараагаараа их тийм нэг уужуу тайван байдаг. Гомбо багшийн дуулах нь гаваргаатай” (Жанцанноров 2005а, 205). “Т.Поврон багш нарийн шуранхайндаа лимбэ шиг, дунд өнгөндөө хонгор дуутай, бүдүүн өнгөндөө их өтгөн дуулдаг байсан, одоо бодоход хоолойн чинээ нь маш өргөн бөгөөд гойд өвөрмөц дуучин хүн байсан” гэж дурссан байдаг. Ж.Дорждагва таван эрдэнэ, таван эрдэм болсон багш нарынхаа хэзээ амарч, хэзээ босдог, хоолойгоо хэрхэн гамнаж

хайрладаг, хоол ундандаа хэрхэн анхаарал тавьж байгаа, биеэ хэрхэн зөв авч явах, хувцсаа хэрхэн тааруулж өмсөх, дуулах нарийн дэг жаяг, аргыг биечлэн яг дэргэд нь сууж заалгаж авсан гавьяатай. Багш Поврон нь 370 дуу дуулж мэддэг байсан (Баасанхүүгийн Шүрхүү 2021) гэхэд Ж.Дорждагва багшийн эн зиндаанд хүрэх тооны дуу дуулдаг байжээ.

Ийнхүү Ж.Дорждагва нь монголын уртын дууны ноён оргил таван дуучдад шавь орж, монголын уртын дууны язгуур ая дан, үг хэллэг, дуулах арга барил, уртын дууны дэг сургуулийг мэргэжлийн түвшинд уламжлан авч үлдсэн нь монголын уртын дуу болон ер нь дуулах урлагт үнэ цэнтэй үүрэг гүйцэтгэсэн байна.

Ж.Дорждагва нь өөрийн таван багшаасаа гадна Монгол орны нутаг хошууны сайн сайн дуучдаас өөрийн мэдэхгүй дуунуудыг сурч авдаг байжээ. Уртын дууг сурна гэдэг зүгээр л нэг дуу сурахтай адилгүй, уртын дуу нь маш олон элемент агуулсан, шүлэг нь гүн гүнзгий утга агуулгатай, маш олон бадагтай, зарим дуу нь 13 түрлэгтэй байсан байна. Ж.Дорждагва нь 200 гаруй дуу дуулахын зэрэгцээ зарим нэг уртын дууг 3-4 аялгуугаар нь дуулдаг байсан нь энэ хүн онцгой тогтоон цээжлэх чадвартай, гоц сонсголтой хүн байсныг илтгэж байна. Ж.Дорждагва нь 1932 онд буюу 28 настайдаа зөвлөлтөөс уригдан ирж ноот зааж байсан А.Кольцов, Ф.Клешко нарын заасан ноотны ухааныг хамгийн түрүүнд сурснаас гадна маш сайн сурсан болохоор зөвлөлтийн мэргэжилтэн, хөгжим судлаач М.Берлина Печникова, М.Дугаржав багшийнхаа хамт 25 (1935) онд 98 богино, 6 урт дууны, 26 (1936) онд 19 урт дууг дуулж эгшиглээст буулгаж, ном болгон хэвлүүлсэн байна. Түүнээс гадна 103 уртын дууг өөрийнхөө дуулснаар ноотолж, 1970 онд “Уртын дуу” хэмээх ном болгон үлдээжээ. Мөн түүнийг анхны найрал дууны багшаар томилон ажиллуулсан байна.

Хоёр: Ж.Дорждагва нь тасралтгүй бүтээн туурвигч дуучин байсан. ... Эцэг Жигзав нь дуучин, хөгжимчин, морин хуур хуурдана, лимбэ дарна. Их гэрийн эзэн Чойсүрэн хаалгачийнх баян айл байсан. Надад их хайртай, би тэднийд л байдаг байсан. 1913 он буюу есөн настай уншлага төгсөж шагнуулаад, шинэ ногоон гөлөмтэй, тас хар морь, мөнгөн эмээлтэй, торгон дээл өмсөж наадамд очдог. Миний хүү эдлэх юмаа эдэлнэ, юм эдлэх азтай юм чинь (Мөнхөө 1990) гэсэн нь түүнийг халамжлан анхаардаг байсны харуулна. Өвөг эцэг Ням жигтэйхэн сайхан хоолойтой. Хадна-ус гэдэг газар тусгай хийдэд лам байсан. Дуулаад бүжиглэдэг “Зузар” гэдэг бүжгийг бүжиглэдэг хүн байсан. Ах Лувсанцэрэн, эгч Маамуу, дүү Палам нь маш сайхан дуулна. Авьяастай хүмүүс эргэн тойронд нь байсан нь түүнийг алдартай дуучин болоход хамгийн их нөлөөлсөн.

1932 онд цэргийн хөгжмийн сургагч байсан Кольцов гэгч орос хүнээр анх ноот заалгаж, хэдэн сарын дараа ноот хараад мандолин хөгжимд ая оруулж чаддаг болсон нь хязгааргүй баяр байв. Ноот сурсан нь түүнийг уртын дууг дараагийн шинэ шатанд гаргахад нь түлхэц болсон.

1930-аад онд оросын хөгжмийн мэргэжилтэн Берлина Печникова төгөлдөр хуурчаар буюу концертмейстрээр ажиллаж байхдаа урт болон ардын дуунуудыг алдартай дуучдаар дуулуулж сонсоод, ноотолж үлдээсэн ба тухайн дуучны дуулах арга барил, дуулах сэтгэлгээ, түүхэн тэмдэглэлийг 25 (1935), 26 (1936) онуудад хэвлүүлсэн гавьяатай. Аудио бичлэгээс ч илүү, ноотыг хараад л дуулна.

Ж.Дорждагва энэхүү түүхэн өв санг хадгалж үлдээхэд хүндтэй оролцсоноос гадна өөрөө бие даан 103 урт дуунуудыг нутаг нутгийн дуулдаг ая дангаар эгшиглээс (өрнө дахины 5 шугам эгшиг бичгийн аргаар)-т оруулан, 1970 онд “Урт дуу” нэрээр хэвлүүлсэн нь дуулаачийн урын санд жинтэй хувь нэмэр оруулсан байдаг.

Мөн ардын урлаг судлагч, СГЗ Жамцын Бадраа 1984-1987 онд, Урлаг судлалын ухааны доктор (Ph.D), профессор, угсаатны хөгжим судлаач Жамбалын Энэбиш 1987 онд монголчуудын олон зууныг дамжуулан тээж ирсэн урлагийн хосгүй төрөл-уртын дууны сонгодог дэг сургуулийг бүрэн төгс эзэмшсэн алдарт дуучны яриа, уламжлалт хөгжмөө гаргуун мэддэг судлаач сэтгэгчийн онож асууж, олж лавлаж байгаа арга ухаан хоёр түүхэн болоод эрдэм судлалын ихээхэн өргөн хүрээг хамарч байгаа далай болсон “Их дуучны яриа” номын амьд яриа нь зуун зууны эрдэмтний эн зиндааны бүтээл юм. Мөн Ф.Смирнов “Монгольская народная музыка” ба “Монгол ардын хөгжим” судалгааны их том номоо бичихдээ гол түшиж ажилласан хүн бол Жигзавын Дорждагва. Тэнд Дорждагва ингэв, Дорждагвын дуулснаар авав гээд яваад байна шүү. Дорждагва нь Смирновын монгол хөгжмийн судлагдахууныг хийхэд гол арга зүйч нь байжээ (Жанцанноров 2014). Мөн үе үеийн уран бүтээлчид, судлаач эрдэмтэд, зохиолчид Дорждагвын хоолойн цараа, дуулах арга зүй, дэг сургууль, өв соёл зэргийн талаар олон арван өгүүлэл нийтлүүлсэн байна.

“Ерөөс Ж.Дорждагва нь ардын урт дууг чадварлаг сайн дуулагч дууны уран сайхныг үнэн зөв эзэмшсэн хүн юм. Дуучин Ж.Дорждагва нь өнгө сайтай хүчтэй хоолойтой, дууг чадмаг эзэгнэн, уян налархай бөгөөд сэтгэлийн хөдлөлтэй дуулдаг хүн” гэж дэлхийн театрын нэвтэрхий тольд тэмдэглэгдсэн байгаа нь хэрхэн ямар бүтээн туурвигч дуучин болох нь тодорхой байна. “Дуулах гэж төрсөн” өгүүлэлд “Байгаль түүнд өвөрмөц өргөн цар хүрээтэй, сайхан, баян хүчтэй хоолойг хайрласан” (Түмэн 2004) гэжээ.

1989 онд Монголын зохиолчдын эвлэлийн холбооны V их хурал дээр Ж.Бадраа хэлэхдээ: “Чухам уртынхаа сайхан дууг сурч судалж, өвлөж дэлгэрүүлэх, хойч үедээ хадгалан хямгадах улирлын сайн цаг одоо болж байгаа шүү. Авьяас билиг төгөлдөр ард олны маань дотор зуу зуун М.Дугаржав, Ж.Дорждагва, мянга мянган Н.Норовбанзад, Б.Лхамжав шиг сайн дуучид одоо ч байгаа, хойшид ч байна гэдэгт эргэлзэх хэрэггүй” гэжээ. Түүнийг багш М.Дугаржавтай нь зүйрлэн нэгэн эгнээнд авч үзэж байгаа нь түүний хэрхэн өндөрт үнэлэгдэж байгааг харж болно.

Ардын дуу бол монголын хөгжмийн урлагийн сонгодог хэлбэр мөн гэж С.Кондратье, Б.Смирнов зэрэг зөвлөлтийн хөгжим судлаачид тодруулсан юм. Монгол ардын урт дууг шастир, айзам, бэсрэг гэж шинжээчид ангилсаар иржээ. Түүнээс гадна Ж.Дорждагва баруун, зүүн, Боржгин гэж хувааж дотор нь Хурх-Биндэр, Хар дэл, Баянбараат гэх зэргээр нутаг орны өвөрмөц онцлогт тодруулах гэсэн шинэлэг оролдлого хийсэн нь анхаарах санаа мөн. Одоо ч энэ онцлогуудаар ангилан судалсаар байна.

Уртын дууны хэлбэр, зохиомж, дуулах арга барилын тухайд уламжлагдаж ирсэн үндэсний өвөрмөц олон зүйл нэр томьёо Ж.Дорждагва авгайн ярианд дурдагдсан нь судалгаа шинжилгээний чухал сэдвүүдийн нэг болох нь ажиглагдаж байна. “Монголчуудын уртын дууны уламжлалт нэр томьёог ард нийтийн зан заншил, ажил үйлсийн хэрэглээний үгсийн сангаас дуулах урлагтай нягт уялдуулан зохицуулж

тогтоосон нь хөгжмийн нэр томъёоны хувьд үндэсний сэтгэлгээний мөн чанарт илүү тохирсон, хөгжим судлалын талбарт үйл хөдлөл-туурвилын хосмолжин санааг өргөжүүлэхэд ихээхэн ач тустай арга ухаан юм байна” (Жанцанноров 2005а, 5). Энэхүү дүгнэлтийг бодит болгон “Уртын дууны уламжлалт зарим нэр томъёоны гаргалгаа” номыг ШУ-ны доктор (ScD) Н.Жанцанноров 120 үг хэллэгийн тайлбар, гаргалгааг багтааж, 2005 онд хэвлүүлсэн нь судалгааны асар их ач холбогдолтой өмнөө барих судалгааны ном болсоор байна.


“Монгол ярианы хэлний өгүүлбэрийн онцлог”, “Амьд ярианы асуулт-хариулт”, “Хоршоо, гуншаа үгийг гойд чамин хэрэглэсэн нь”, “Хочоор нь нэрлэж ярилцах нь холбоо найруулгыг амтгай болгодог...”, “Тодорхой мэргэжлийн хүрээний энгийн амьд яриа”, монгол хүмүүний харилцах, мэдлэг мэдээлэл солилцох хам хүрээ хэрхэн яаж бүтэж бүрэлддэг, өгүүлэгч-сонсогч хоёрын мэдрэмж, ярианы асуулт-хариултын цогцлоос (“реплика”), өгүүлбэрүүдийн бүтэц, хэв маяг, найруулга, үг-өгүүлбэрийн эхлэл, төгсгөл, хэлбэржилт, орхилт, зогсоц, утга санааны уялдаа, үг-өгүүлбэрийн өнгө аяс, эрчим энерги, баймжууд, аялгын хэлбэржилт, ярианы хэлбэрийн өгүүлбэрийг хувиргах аргууд, ам нээх, асуух холбох маяг, эгшиглүүлэх, хураах болон дэлгэрүүлэх ёсон, үг хэллэгийн сонголт, хөндлөнгийн оруулбарууд гэх мэт эх судлалын онол-аргазүй, хэрэглээний олон асуудлыг амьд баримтаас үүдүүлэн, улируулан судлахад “Их дуучны яриа” ном ёстой нэг амьд хэрэглэгдэхүүн болмоор санагдана. А-Я хүртэл нийт 80-аад уртын дуу дурдагдаж, тэдгээрийн ая дан, дуулдаг арга ухаан, ур хийц, дэг барил, дуулсан дуучид, хуурчид...гэх зэрэг их бага 70 гаруй хүний нэр, тэдний ур ухаан, амьдрал явдлаас нь мэдээ мэдээлэл, хууч яриа оржээ. Мөн өдөж хөтөлсөн асуулт, дотоод гадаад ярианы эсрэг хариултын хослол буюу “реплика” /энэ нь франц гаралтай үг бөгөөд эсрэг санал, хариулт, асуулт-хариултын цогц мэдээлэл гэсэн утгаар хэрэглэгддэг/ нийтдээ 300 гаруй байна. Монгол ардын уртын дууны уламжлалт нэр томъёо мэргэжлийн үг хэллэг, түүний утгын тайлбар, хувилбарыг багтааж ирсэн нь дуу хөгжим, соёл судлаач нарт судалгааны үнэ цэнтэй хэрэглэгдэхүүн болж байна. Ж.Дорждагва гуайн амьд ярианы толь ч гэмээр, янз бүрийн чиглэлтэй задаргааг хийж болох үнэ цэнтэй ном. Ялангуяа илтгэх урлаг, монгол ярианы хэлний өгүүлбэр зүй болон уртын дуу түүний үг хэллэгийн судалгааг тал талаас нь ургуулан хийж болох баялаг сайхан хэрэглэгдэхүүн юм байна (Пүрэв-очир 2009, 246).

Ж.Дорждагвын судалгаа дотоодод болон олон улсын хэмжээнд хаяа тэлсээр судлагдсаар байна. 2008 онд “Хүн төрөлхтний Соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалт”-д уртын дууг ЮНЕСКО-д бүртгүүлэхэд Ж.Дорждагвын судалсан, дуулсан бүхэн тодорхой нөлөө үзүүлсэн.

Мөн 2004 онд 100 насны ойгоор “Ази тивийн сонгодог уртын дуу, түүнийг өвлөн тээгчид” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал, 2014 онд “Талын их дуучин” баримтат кино, түүхэн гэрэл зургийн үзэсгэлэн дэглэсэн, түүний нэрэмжит олон улсын уртын дуучдын уралдаан зохиосон, 2005, 2014 онд “Их дуучны яриа” ном, Алдарт дуучин Дорждагвын ардын билэг зүйч Ж.Бадраа нарын амьд ярилцлагыг Франц улсын INA (Institut national de l'audiovisuel) буюу дууны үндэсний институт байгууллагад сэргээлгэж, “Их дуучны яриа” ном 2023 онд англи хэлээр, амьд яриа нь англи хэлээр хадмал бичигтэйгээр DVD хэлбэрээр хэвлэгдэж, дэлхийн сонорт хүрсэн нь түүний бүтээн туурвисан бүхний үнэ цэнийг тодотгож байна.

Бүтээл туурвилгийг тодорхойлох түлхүүр (Хүн төвөг системийн хандлага)

Загварын эх сурвалж: Д.Ариунаа "Националь Жаншанноровын хөгжмийн бүтээл дэх үндэсний сэтгэлгээний илэрхийллийн асуулалд" Дисс. 2022. х.156



Хэлэлцүүлэг

Нэрт дуучин Ж.Дорждагва нь монголчуудын олон зууныг дамжуулан тээж ирсэн урлагийн хосгүй төрөл-уртын дууны сонгодог дэг сургуулийг бүрэн төгс эзэмшсэн түүчээлэгч алдарт дуучин мөн. Ж.Дорждагвын Жамцын Бадраа, Жамбалын Энэбиш нартай ярилцсан амьд ярианы бичлэгээс түүчээлэгч алдарт дуучин гэдэг нь тодорхой харагдана. Монгол Улсын хэмжээнд одоогийн байдлаар Дорждагвын талаар судлагдхуун болохоор эрдэмтэн мэргэдийн гурван ном, эрдэмтэн судлаачдын өгүүлэл, тэмдэглэлүүд, урлаг судлалын ухааны докторуудын болон шинжлэх ухааны докторын диссертацид дурдагдан хэвлэгдсэн байна. Мэргэжлийн урлагийн театр чуулгуудын ойн арга хэмжээн дээр Ж.Дорждагвын нэр байнга дурдагдаж түүний дуулсан дуугаар тухайн тоглолтын арга хэмжээ нээлтээ хийж байдаг нь түүний авьяас билгээ хойч үедээ залгамжлан үлдээсний гэрч билээ. Монголын уламжлалт уртын дуу гэж байгаа бол монголын уламжлалт дууны соёл, дуун соёлыг шинэ цагийн асуудлыг уламжлалтай хослуулан ярихдаа ямар ч гэгээнтэн, ямар ч хувилгаан, ямар ч гоц судлаач Ж.Дорждагвыг тойрч судлах, тойрч ярих ямар ч боломж байхгүй (Жанцанноров 2014). Доёо багш бол хүн төрөлхтний дуучин (Жанцанноров 2014). Жигзавын Дорждагва гуай бол зууны биш мянганы дуучин шүү (Лхагвын Эрдэнэбулган 2019).

Ж.Дорждагва нь 1959 оны өгүүлэлдээ: “Монгол үндэсний урт богино дуунууд нь бид бүхний эзэмшин суралцвал зохих эрдэнэ мэт өв сан юм. Ялангуяа өсөх залуу үеийн дуучдад ардын үндэсний урт дуугаа сурч судалж хөгжүүлэх нь тэдний эрхэм үүрэг мөн. Ардын үндэсний дууг аялгууны хувиар урт богино гэж хоёр хувааж утга агуулгын хувиар 9 хэсэг болгож үздэг. Үүнд: 1. Утга уянгат дуу, 2. Аж байдлын уянгат дуу, 3. Хөдөлмөрийн дуу, 4. Хувьсгалын дуу, 5. Түүхэн дуу, 6. Эмгэнэлийн дуу, 7. Хошин шог дуу, 8. Шажин мөргөлийн дуу, 9. Бичгийн гаралтай дуу гэж хуваасан байна. ... үндэсний урт богино дуунуудынхаа үг бүхний нь судлан мэдэж, ая бүхний нь яруу сайхнаар аялан дуулж чаддаг болохын төлөө тэмцэх нь чухал. ... Ардын урт дуунуудаа бүгдийг нь бүртгэн бичиж, аялгуунуудын нь ноотолж, урт богино дуунуудын эмхэтгэсэн дэвтрүүдийг бий болгох нь чухал” (Дорждагва 1959, 7). Энэ зөвлөлгөөндөө дуучдад сануулах, анхааруулах, шүүмжлэх, дуучин болох гурван аргыг заасан, ямар үр дүнд хүрэх, дутагдал нь юу байна, судлах хэрэгтэй, хайрлаж хамгаалж дуулах тухай маш сайхан зөвлөгөөг өгчээ.

XX зууны гарамгай уртын дуучин Жигзавын Дорждагва, монголын соёлын нэртэй зүтгэлтэн Жамцын Бадраа нарын 1987 онд хүүрнэсэн 16 цагийн бичлэг бий. Энэ бичлэгийн агуулга нь монголын уртын дууны үүсэл, хөгжил түүхэн замнал, XX зууны эхэн үе XIX зууны төгсгөлд монголчуудын уртын дуугаа дуулж байсан дөрвөн том аялгуу, ая дан буюу Хурх биндэр, Баян бараат, Боржгин, Хар дэл энэ аялгуунуудын гол гол тухайн үед дуулж байсан төлөөлөгч нар, тухайн аялгууны онцлог, олон хоолойны хөдөлгөөн, уртын дуу дуулдаг арга техник, амьсгалын техник зэрэг ийм зүйлүүдийг хүүрнэж өгүүлсэн, тэр дундаа манай нэртэй дуучин Ж.Дорждагва гуай 272 удаа дуу аялж, хоолойны нарийн техникүүд, амьсгалын арга техник, хоолойн хөдөлгөөнүүдийг үзүүлж, түрүү дурдсан дөрвөн том аялгуунууд дээр байж байгаа дуунуудыг хэрхэн яаж ямар хэлбэрээр дуулдаг байсан тэр арга барилыг дэлгэж өгүүлсэн, үнэлэхийн бол бидний өнөөдөр хамгийн бодитой,

хамгийн гарамгай, хамгийн сайн мэдэж байсан сүүлчийн бодит өв болсон бичлэг байгаа юм. 2017 онд энэ 10 хуурцагийг сэргээж, “Их дуучны яриа” ном англи хэл дээр, 2023 онд ном болон DVD-ээр хэвлэгдсэн нь дэлхийн хүн төрөлхтний оюуны их ололт, өв, сан болж уртын дууг залгамжлан авсан, соёлын цогц ундрагатай Жигзавын Дорждагва гэдэг хүний Жамцын Бадраа гуайтай ярилцсан бичлэг нь монголын уртын дууны дуулах арга барил, үүх түүх, ёс журам, дэг соёл, намтар цадгийн маш томоохон судлагдхуун болж байна.

Японы монголч эрдэмтэн Онишисан “Танай алдарт дуучин Ж.Дорждагва бол дэлхийд нэрээ мандуулж домог болсон хүн юм аа” гэж хэлсэн байдаг. Дэлхийн театрын нэвтэрхий толь бичигт “Ж.Дорждагва нь ардын уртын дууг чадварлаг сайн дуулдаг, дууны уран сайхныг үнэн зөв эзэмшсэн ба цэвэр тунгалаг өнгөтэй хүчтэй хоолойтой хүн юм. Тэр дуулах урлагийг чадамгай эзэмшин, дууг уян налархай бөгөөд сэтгэлийн хөдлөлтэй дуулдаг” гэж бичсэн байдаг. Ж.Дорждагва нь дэлхийд нэрээ дуурсгасан дэлхийд данстай хүн юм.

Болгар улсын хөгжмийн холбооны орлогч дарга, хөгжмийн шинжлэх ухааны доктор Винлин Кростов “Танай ардын дуу дуулаачид нь дуугаа доод, дунд, дээд өнгөндөө хэрхэн дуулж амьсгалаа авах талаар дээдийн дээд мэргэжсэн дуучид байна” гэж үнэлсэн. 1970 онд ардын хувьсгалын 50 жилийн ойтой холбогдуулан Зөвлөлт Холбоот Улсын Хөгжмийн зохиолчдын хорооны урилгаар зочлон очиж, хөгжмийн зохиолчидтой уулзсан уулзалтаар алдарт гавьяат дуучин Ж.Дорждагва гуайн дуулсан “Дуртмал сайхан” дууг соронзон бичлэгээр сонсоход, уулзалтад оролцсон хөгжмийн зохиолчид алга ташин угтсан. Хөгжмийн шинжлэх ухааны доктор Иван Иванович Мартынов “Танай дуучин дээд доод өнгөндөө яаж дуулах, хоёр өнгөний хооронд хэрхэн шилжих, арга техникийн гэсэн гурван сургуульд суралцаж байж дуулмаар дуу дуулж байна. Одоо хэдэн нас хүрч яваа хүн бэ? Уртын дуу дуулж сурсан арга техникийг нь судалж байна уу? гэсэн асуултад: 70 нас сүүдэр дөхөж яваа, ардын уламжлалаар дуулж сурсан, арга техникийг нь судлаагүй байна” гэж хариулсан. Доктороос арга техникийг судлан залуу дуучиддаа эзэмшүүл гэсэн хатуу зэмлэл сонсож байлаа (Бирваа 2016, 71).

Дооёо багшийн үед манай гадаад харилцаа тийм өргөн биш байсан учраас дэлхийн тайзан дээр яваад дуулах боломж бололцоо тухайн нөхцөл бүрдээгүй. Тэрнээс биш Дооёо багш бол хүн төрөлхтний агуу дуучин (Жанцанноров 2014). Шавь нар нь гадаад дотоодын олон оронд уртын сайхан дуугаа эгшиглүүлсэн нь бахархалтай.

Ж.Дорждагвын зохиосон уран бүтээл нийтдээ 55 байгаагаас төрөл зүйлээр нь ангилвал 45 буюу 81.8 хувь, шүлэг 9 буюу 16.3 хувь, ерөөл 1 буюу 1.8 хувь байна.

Нийт 45 дууны уран бүтээлийг төрлөөр нь ангилвал, уртын дуу 6 буюу 13.3 хувь, зохиолын дуу 30 буюу 66.6 хувь, дуурь ба хөгжимт драмын жүжгийн дуу 7 буюу 15.5 хувь, найрал дуу 3 буюу 6.6 хувь байгаагаас зохиолын дуу хамгийн их буюу 66.6 хувийг эзэлж байна.

Үүнээс хувьсгалын сэдэвтэй дуу 9 буюу 20.0 хувь, эх орон эх дэлхийн сэдэвтэй дуу 34 буюу 75.5 хувь, байгаль ан амьтны сэдэв 2 буюу 4.4 хувийг эзэлж байгаа нь тухайн цаг үе нийгмийн хөгжил дэвшүүлж байсан бодлоготой холбоотойгоор эх орон, ажил үйлсийн сэдэвтэй дуу зонхилж зохиогдож байсныг харж болно. Мөн гурван дууны шүлэг, аялгууг дагнан зохиожээ.

Ж.Дорждагватай хийсэн ярилцлагыг ном болгон гаргасан хоёр том судалгааны археологи болсон ном байгаа ба түүнээс үүдэлтэй судалгааны нэг ном, судлаачдын өгүүллүүд хэвлэгдсэн байна. 1959, 1968 оны “Соёл” сэтгүүлд уртын дууны судалгааны талаар өгүүлэл хэвлэн нийтлүүлжээ.

Дүгнэлт

Алдарт дуучин Ж.Дорждагва 1932 оноос насан эцэслэтэл (1991) уртын дууны багш, уртын дуучин, найрал дууны багш, уран сайхны удирдаач, уртын дууны гэрийн багшийн үүргийг тасралтгүй хашсан юм. Тэрээр уртын дууны дуучдыг бэлтгэх, уртын дууг хөгжүүлэхэд бүх амьдралаа зориулсан бөгөөд уртын дууг мартагдахаас хамгаалахад өөрийн авьяас, хүчээ бүрэн дайчилсан билээ. Түүний хүчин чармайлт нь монгол уртын дууг өнөөгийн түвшинд мэргэшсэн боловсон хүчинтэй болгоход үнэтэй хувь нэмэр оруулсан гэж үнэлэгддэг. Ж.Дорждагва үеийн удирдагчидтай хамтран ажиллаж, тэдэнтэй зөвлөлдөн, уртын дууг архив, сан хөмрөгт бүртгүүлэн үлдээж, сэргээн дуулах, үгийг нь тухайн үеийн үзэл сурталд нийцүүлэн өөрчлөх, ноотлох, дуулах арга барилыг боловсруулж, түгээн дэлгэрүүлсэн алдартай дуучин байв.

Нэг: Дорждагвын дуулж үлдээсэн уртын дуунуудад задлан шинжилгээ хийж судлахгүй байна. Бүх монголын алдартнуудаар багшлуулсан хүн учраас тэр талын гоёос нь, энэ талын сайнаас нь, тэр талын мундагаас нь нэг дуун дээр овоолоод байгаа юм... дуу нь хаанахых ч биш болоод байна. Людвиг ван Бетховен баруун европын шилдэг зохиолчдын аргуудаас судалж байгаад өөрийнхөө зохиолыг туурвисан байдаг. Төгс болгосон байгаа юм. Жигзавын Дорждагва бол Людвиг ван Бетховен шиг нөхөр байгаа юм. Ж.Дорждагвын дуулсан “Дуртмал”-д хэнтий зүгийн, хангайн зүгийн, Боржгоны болон Баян бараатын юу байж болох вэ гэдгийг хайж судлах хэрэгтэй байна. Таван багшийн дэг сургуулийг ялгаж судлах хэрэгтэй. Монголын уламжлалт уртын дууны аялах, бодох сэтгэх, уран сайхнаар илэрхийлэх сонгодог дэг нь Дорждагва гуай дээр ирж боловсрогджээ гэсэн ойлголт гарч ирж байна (Жанцанноров 2014).

Залуу судлаачид, дуучид энэ цаг үед амьдарч байгаа эрдэмтэн судлаачидтай хамтарч ажиллах талаар бодлого баримтлахгүй байгаа нь дууны үг, аялгууг зөрүүтэй дуулах, техник технологийн хөгжлийг дагаж хэт саармагжуулж байгаа нь уламжлалт язгуур төрхийг алдагдуулж байгаа нэг шалтгаан болгож байна.

Хоёр: Бид хамтдаа ярих, хамтдаа төлөвлөж хийх асуудал маш их байна. Залуучуудыг эрдэмтэд нь дэмждэг, залуучууд нь эрдэмтэдтэйгээ хамтран судалгаа хийх асуудлууд байна. Төрийн дуучингүй (эрэгтэй) боллоо гэж халаглан байсныг бид байнга санаж байх хэрэгтэй. Ер нь бид дэлхийн хөгжлийн жишгээс хоцронгуй байх гээд байна. Уртын дууны сургалтын хөтөлбөрийг Ж.Дорждагвын сургалтын заах аргаас нарийвчлан судлах хэрэгтэй байна. Түүнээс таван багшийн заах арга гарч ирнэ. Энэ нь төгсөж байгаа суралцагсдын түвшин тухайн салбарынхаа шинжлэх ухааны ай савыг бүрэн хангаж судалж чадахгүй байна. Монгол ардын зүйр цэцэн үгэнд байрнаасаа хөдөлсөн чулуу мөддөө байраа олдоггүй гэдэгтэй адил Дорждагва судлал-уртын дууны салбар байх ёстой байрандаа очиж чадахгүй байна.

а/ Монголын уртын дууны гарал үүсэл, сурвалж тэмдэглэл, яриа дурсамж, үг хэллэг, дуулах ухаан, арга барил, дэг сургуулийг дуу хөгжмийн онол арга зүйгээр судалж тодорхойлсон явдал нь урьд өмнө хийгдэж байгаагүй судалгаа шинжилгээний чиг хандлага бөгөөд монголчуудын уламжлалт дуулах эрдэм ухааныг гаргаж, шинэ чиг хандлагаар харах боломжийг буй болгож, монголд төдийгүй дэлхий дахинд таниулсан.

б/ дэлхий дахинд техник технологи хурдтай шинэчлэгдэн өөрчлөгдөж буй “Цахим болон аж үйлдвэрийн IV хувьсгал”-ын харилцааны тогтолцоонд Монголчуудын дуун ухаан, илтгэх урлаг, ардын язгуур урлаг, ялангуяа дуу хөгжмийн урлаг соёлын уламжлал, туршлага, сургамж, өв санг судалж тодорхойлж өгснөөрөө “монголчуудын өв соёл”-ын гайхамшигийг батлах нэгэн нотолгоо болсон юм.

в/ Дээрх бүх эх сурвалжийг хадгалж хамгаалж, түгээн дэлгэрүүлж, уншиж судлах үйл явцыг онол арга зүйн түвшинд авч үзэн судалсан нь “Уртын дуу-уртын дууны судлал”-ын чиг хандлагыг тогтоож өгсөн нь Монгол Улсын соёл урлаг, боловсрол, шинжлэх ухааны салбарт оруулсан дорвитой бодит үр дүн юм.

Туурвисан бүтээл, дуулсан дууны цар хүрээнээс тунгаан дүгнэхэд Монголчуудын дууны урлаг тэр дундаа ардын дуу, уртын дуу, хэл шинжлэлийн ухаан, түүхийн хүрээний салбарт хамааралтай нь цаашид төрөл зүйлээр нь задлан шинжлэн судлах зүйтэй. Жигзавын Дорждагва нь өмнөх үеийнхээ уртын дуучдын туршлага, төв халхын айзам уртын дууны сонгодог уламжлалыг ХХ зууны хоёрдугаар хагастай залгуулж, уламжлал, шинэчлэлийн залгамж холбоог хангахад түүхэн үүрэг гүйцэтгэсэн үндэсний соёлын гарамгай зүтгэлтэн мөн. Алдарт дуучин Дорждагва нь монголын уртын дууг шинэ шатанд гаргах үйлсэд түүчээлэн ажилласан алдарт дуучин, монголын уртын дууны гайхамшигийг монголд төдийгүй дэлхийн хүн төрөлхтөнд үлдэхэд үнэ цэнтэй өв соёлыг үлдээж чадсан “Соён гэгээрүүлэгч хүмүүн” мөн. “Уртын дуу гэдэг бол монголчуудын оршин тогтнох эх үндэс мөн” гэсэн алдартай үгээр өгүүллээ өндөрлөж байна.

Ашигласан материалын жагсаалт

Ардыг гэгээрүүлэх яам. 25 (1935) /дахин хэвлэлт 2021/. *Монгол дуунуудын түүвэр*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

Ариунаа, Д. 2022. “Нацагийн Жанцанноровын хөгжмийн бүтээл дэх үндэсний сэтгэлгээний илэрхийллийн асуудалд.” Ph.D дисс., Монгол Улсын Соёл урлагийн их сургууль.

Бирваа, Г. 2016. *Эх орон эцэг эхээс улбаатай*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.

Ганхуяг, Найдан. 2010. *Монголын театрын нэвтэрхий толь*. Улаанбаатар: Бемби сан.

Дашдорж, Д., Цоодол, С. 1971. *Ардын дуу хөгжмийн суу билигтнүүд*. Улаанбаатар: Улсын хэвлэх үйлдвэр.

Дорждагва, Ж. 1959. “Ардын уртын дууны төв сангаас сурцгаая”, *Соёл сэтгүүл*, 1959/№4.

Жанцанноров, Нацаг. 2005. *Их дуучны яриа*. Улаанбаатар: Адмон принт.

Жанцанноров, Н. 2023. “Монголын орчин цагийн хөгжмийн онолын үндсэн асуудлууд.” Sc.D дисс., Монгол Улсын Соёл урлагийн их сургууль.

Наранчимэг, Цэнд. 2019. *Гурвансайхан ижий*. Улаанбаатар: Адмон принт.

Оюунцэцэг, Д. 1990. “Монголын дуулалт-яруу найргийн төрөл уртын дууны гарал, хувьсал.” Ph.D дисс., Москва хотын П.И.Чайковскийн нэрэмжит консерватори.

Оюунцэцэг, Д. 2010. *Монголын дуулалт-яруу найргийн төрөл уртын дууны гарал, үүсэл*. Улаанбаатар: Адмон принт.

Смирнов, Б. 1975. *Музыка Народной Монголии*. Москва:

Энэбиш, Жамбал. 2014. *Их дуучны яриа II*. Улаанбаатар: Адмон принт.

Ярилцлага:

Самбуугийн Энхбулаг (Монгол Улсын Консерваторийн багш)-тай хийсэн ярилцлага. Улаанбаатар хот: Монгол Улсын Консерватори 402 тоот, 2023.01.15.

Төрийн дууч Гэлэнгхүүгийн Повронгийн тухай Баасанхүүгийн Шүрхүүтэй хийсэн ярилцлага. Улаанаатар, 2022.03.07.

Кино:

Жанцанноров, Нацаг. (зох), Цагаанчулуун, Лхагвабаатар. (найр). 2014. *Талын их дуучин*. NTV. 1:19:18 минут.

Дуу, хөгжмийн бичлэг:

Жамцын Бадраа, 1987. *Их дуучны яриа*. Цагаан кассет. 1987.

Жамбалын Энэбиш, 1987. *Их дуучны яриа II*. Цагаан кассет. 1987

Jantsannorov, Natsag. 2023. *Mongolian national LONG SONG overview: Dorjdagva JIGZAVIN, Badraa JAMTSYN*. DVD.

Дорждагва, Ж. 2003. “Мөнх тэнгэрийн аялгуу-уртын дууны цомог” 1, 2, 3.